



ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 05 ДУГААР САРД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2022.05.25

Дархан-Уул аймаг

1. ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛ

Газар зохион байгуулалтын төлөвлөлт, өмчлөлийн хүрээнд:

- Газрын кадастрын мэдээллийн санд нөхөн бүрдүүлэлтээр оруулах шаардлагатай нэгж талбарын судалгааг гарган ажилласан. Дархан сумын нийт 18 багийн иргэн хуулийн этгээд болон төрийн байгууллагуудын газар эзэмших цахим гэрээ, гэрчилгээг үүсгэн ажиллаа. Нийт 247 нэгж талбар



Монгол Улсын иргэнд газар өмчлүүлийн чиглэлээр:

- Дархан-Уул аймгийн хэмжээнд Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль хэрэгжиж эхэлсэнээс хойших хугацаанд өмчлүүлсэн газрын судалгааг гаргаж ажилласан.
- Аймгийн хэмжээнд 2022 онд 445 иргэнд 35,05 га буюу хуучин эзэмшиж байгаа газрыг газрыг өмчлүүлэхээр төлөвлөсөн. Дархан сумд 1, 2, 3, 5, 6, 7, 8, Малчин багийн нутаг дэвсгэрт 195 иргэнд 65 га газрыг 2022 онд өмчлүүлэхээр батлагдсан.
- Аймгийн Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон Прокурорын газарт шалгагдаж байгаа иргэн, хуутгээдийн нийт 25 албан бичгийн лавлагааг мэдээллийн сан болон газар өмчлөх захирамжаас шүүж хариуг хүргүүлсэн.

Геодези, зураг зүйн, кадастрын хүрээнд:

- Хаягийн зургийн дагуу 28 иргэн, 4 аж ахуйн нэгжийн эзэмшлийн газар, үл хөдлөх эд хөрөнгөд хаяг дугаар олгосон.
- Шинээр үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ авахаар /хувийн сууц, гараж, барилга байгууламж/ хэмжилт хийлгэсэн 18 иргэн, 3 аж ахуйн нэгжийн материалыг хүлээн авч мэдээллийн санд оруулж кадастрын зураг гаргасан.
- Өмчлөх эрхээ бусдад шилжүүлэх хүсэлтээ цахимаар ирүүлсэн 32 иргэний материалыг хянаж өмчлөх эрхийг шилжүүлсэн.
- Геодези, зураг зүйн, кадастрын зураглалын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй "Гео од" ХХК-ний хийж гүйцэтгэсэн



- ✓ "Сигма Эс" ХХК-ны 25-н айлын орон сууцны барилгын гүйцэтгэлийн ажлыг шалгаж хүлээн авсан.
 - ✓ Орхон сумын нутаг дэвсгэрт гахай шувууны аж ахуй эрхлэх иргэн аж ахуйн нэгжид олгох газрын улаан шугамыг тавьж тэмдэгжүүлэх ажлыг хийж гүйцэтгэхэд оролцсон. Нийт 190 солбицолыг газарт шилжүүлж 47 нэгж талбарыг шохой асгаж тэмдэгжүүлсэн.
 - ✓ "Дэлгэрэх бат дэвжих" ХХК-ны орон сууц, үйлчилгээний цогцолбор барилгын улаан шугам
 - ✓ Миний Монгол цэцэрлэгт хүрээлэнгийн дугуй барилгаас хөшөө хүртлэх явган замын улаан шугам
 - ✓ Хонгор сум. 3 дугаар баг спорт заалны барилгын улаан шугамын ажлыг шалгаж хүлээн авсан.
 - ✓ "Эм Жи Эл тунель системс" ХХК-ний 180 айлын орон сууцны барилга улаан шугам
- ✚ Зөвшөөрөлгүй хашаагаа сунгасан 3-р баг Угалзын 3-30а, 6-р баг Тээвэрчдийн 1-1,16, авто замын трасст орсон 2-р баг Хушаатын 1-р гудамж 7 тоот айлуудад мэдэгдэх хуудас хүргэсэн.
- ✚ Мал бүхий иргэдийн сууршлийн бүсийн хаяг дугаарын зургийг гаргаж хүргүүлсэн.

Газрын суурь судалгаа, мониторингийн хүрээнд:

- ✚ Захиалгат хянан баталгааны мэдэгдэх хуудас 20 нэгж талбарт үүсгэв.
- ✚ Захиалгат хянан баталгааны 28 тайлан баталгаажуулж 5 тайланг хянаж буцаасан.
- ✚ Газар ашиглалтын зориулалт өөрчилж, газар эзэмшүүлэх тухай захирамжийг үндэслэн Цахим гэрээ гэрчилгээг 79 нэгж талбарт үүсгэв.
- ✚ Улсын бүртгэлийн Э дугаар авах 2 иргэний гэрчилгээг шинэчлэв.
- ✚ Байгууллагын цахим төвд 2022.05.16,23-ний өдрүүдэд сууж иргэдэд зөвлөгөө өгч, цахим хүсэлтийг илгээж ажиллав.
- ✚ Газар өмчлөөгүй гэсэн лавлагааг 47 иргэнд 49 хүүхдэд гаргаж өгч үйлчилсэн.
- ✚ Орц гарц хаасан тухай 2 иргэний өргөдлийн дагуу мөн зөвшөөрөлгүйгээр нийтийн эзэмшлийн талбайд хашаа сунгаж барьсан 1 иргэн, 1 хуулийн этгээдэд 14 хоногийн хугацаанд зөрчлөө арилгах тухай шаардах хуудас хүргэж ажиллав.
- ✚ Дүйцүүлэн хамгаалах газрын судалгааг Байгаль орчин аялал жуулчлалын газрын мэргэжилтэн Д.Баянмөнхтэй хамтран хийж гүйцэтгэв.





Газрын төлбөрийн талаар:

✚ Газрын төлбөрийн тухай хуулийн 6.3-д 2021.07.07-ны өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт орж "сум, дүүргийн" гэснийг "аймаг, нийслэлийн" гэж өөрчлөлт оруулсан бөгөөд 2022.01.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаатай холбогдуулан Дархан-Уул аймгийн хэмжээнд "Газрын төлбөрийн итгэлцүүрийг хэрэглэх газрын зааг, хязгаар, итгэлцүүрийн тоон утга"-ыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн ээлжит 9 дүгээр хуралдаанаар 2022.03.21-ний өдөр хэлэлцэн батлуулсан. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас дүгнэлт ирүүлсний дагуу засварлан эцсийн байдлаар мэдээллийн санд бүртгүүлэхээр хүргүүлсэн.

✚ 2022 онд аймгийн хэмжээнд 36 нэгж талбарт газрын дуудлага худалдаа зохион байгуулах, Дархан сумын хэмжээнд байгаа 1300 гаруй гаражийн судалгааг гаргаж багийн Засаг дарга нарт хүргүүлсэн бөгөөд ГАРАЖуудын хаалгыг нэг ижил СААРАЛ өнгөөр будуулах, хаалганы гадна хүрээг цагаанаар будуулах, эмульсдэх нэгдсэн хаягжуулалтын ажлыг эхлүүлсэн байна. Энэ ажлын хүрээнд 5-р сард 86 гаражид хаяг олгож, будуулсан байна. Мөн 9, 12-р багийн нутаг дэвсгэрт байрлах гаражуудын хувийн хэргийг нэг бүрчлэн архиваас татаж танилцан, шинэчилсэн бүртгэлд орсон эсэхийг шалгаж шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

✚ 12-р багт 179 гаражийн мэдээлэл манай байгууллагын архивын мэдээллийн санд бүртгэлтэй байна. Үүнээс 5 иргэнд хугацаа сунгах тухай утсаар мэдэгдэж, 13 гэрээг нөхөн бүрдүүлж мэдээллийн санд оруулсан, 9 гэрээний кадастрын зураг байхгүй, байршил тодорхойгүй, утасны дугааргүй тул шинэчлэх боломжгүй байна.

✚ 9-р багт 349 гаражийн мэдээлэл манай байгууллагын архивын мэдээллийн санд бүртгэлтэй байна. Үүнээс 4 иргэнд хугацаа сунгах тухай утсаар мэдэгдэж, 4 гэрээг нөхөн бүрдүүлж мэдээллийн санд оруулсан, 6 гэрээний кадастрын зураг байхгүй, байршил тодорхойгүй, утасны дугааргүй тул шинэчлэх боломжгүй байна.

✚ Газар өмчлөлийн 2070 нэгж талбарын хөрөнгийн бүртгэлийг нэг бүрчлэн аймгийн Татварын удирдлагын нэгдсэн системд илгээж, газрын татварын нэхэмжлэлийг үүсгэсэн.

✚ Газрын эрх зүйн харилцааг хянан шийдвэрлэх 2022.05.20-ны өдрийн хурлаар 43 иргэний гаражийн асуудлыг танилцуулж, захирамжийн төсөлд илгээлээ.

✚ Аймгийн хэмжээнд 2022.05.24-ний өдрийн байдлаар 231 барьцааны гэрээ бүртгэж, цахимаар төлбөрийн даалгавар үүсгэж төлүүлсэн байна. Үүнд: Дархан 94, Орхон 21, Хонгор 115, Шарын гол 1 барьцаа бүртгэсэн байна.

✚ Аймгийн хэмжээнд 8315 хүчинтэй гэрээнд ногдол үүсгэснээс 8241 гэрээнд 1.5 тэрбум төгрөгийн нэхэмжлэл үүсгэж Татварын удирдлагын нэгдсэн системд илгээсэн байна.

Шарын гол сум:

Орхон сум:

Сумын засаг даргын захирамжаар нийт 40 иргэний хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн. Үүнээс газар эзэмшүүлэх 3, хугацаа сунгах 2, өмчилсөн газрын талбайн хэмжээ өөрчлөх 6, эзэмшил газрын талбайн хэмжээ өөрчлөх 11, газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэх 11 хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн байна.



Газар зохион байгуулалтын цахим системд бүртгэлгүй Орхон сумын 1, 2-р багийн нийт 53 иргэнтэй холбогдож нөхөн бүрдүүлэлтийн ажилтай холбоотой мэдээллийг хүргэсэн үүнээс 21 иргэн ирж нөхөн бүрдүүлэлтэнд хамрагдсан байна.

Газар эзэмших эрхийн гэрээ гэрчилгээ шинэчлэх хүсэлтэй 35 иргэний газарт дундын мэдээллийн сангаар дамжуулан Э дугаар авч газар эзэмших эрхийн гэрчилгээг бичиж гэрээ байгуулсан. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчилж авсан иргэний худалдах худалдан авах гэрээ 41, кадастрын зургаар 41 иргэнд үйлчилсэн.

Тайлант хугацаанд нийт 12 иргэнтэй газрын төлбөрийн 2.140.500 тооцоо нийлж газрын төлбөрийг төлүүлсэн байна.

Газрын кадастрын мэдээллийн санд нөхөн бүрдүүлэлтийн ажлаар цахим системд 47 иргэний мэдээллийг оруулсан байна.

2. БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛ

Барилга байгууламжийн ашиглалтад оруулах комиссыг зохион байгуулсан талаар:

- ✚ Засгийн газрын 2011 оны 212-р тогтоолоор батлагдсан Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм, Дархан-Уул аймгийн засаг даргын 2021 оны 01-А/313 тоот томилогдсон захирамжийн дагуу барилгын техникийн бичиг баримтыг хянаж үзэн 2 барилгад ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. Үүнд:
 - “Баян бридж” ХХК-ний үйлчилгээтэй 54 айлын орон сууцны барилга
 - Дархан сум, 14-р баг, Сигма эс ХХК-ний 25 айлын орон сууц



Барилга байгууламжийг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон талаар:


- ✚ Засгийн газрын 2021 оны 213 дүгээр тогтоолын дагуу барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг 9 барилга байгууламжид олгосон. Үүнд:
 - Дархан сум, 11-р баг “Стронгер” ХХК-ний 156 айлын орон сууц
 - Дархан сум, 10-р баг, “Монбамбай” ХХК-ний 45 айлын орон сууц
 - Дархан сум, 9-р баг, “ЦЦТО” ХХК-ний 54 айлын орон сууц
 - Дархан сумын 5,6,7-р багийн ТК27-ТК39 худгийн хооронд дулааны шугам
 - Дэлгэрэх бат дэвжих ХХК-ний үйлчилгээний барилга




- Ган дизель ундарга ХХК-ний үйлчилгээний барилга
- Дархан-Уул аймаг, Хонгор сумын "Спорт заалны барилга"
- "Дэлгэрэх бат дэвжих" ХХК-ний худалдаа үйлчилгээний А,С блок 36.0*80.0м, В блок 120.0*40.0м хэмжээтэй цогцолбор барилга
- "Стронгер" ХХК-ний 156 айлын нийтийн орон сууцны барилга

Баригдаж байгаа барилга байгууламжуудад хяналт шалгалт хийсэн талаар:

- ✚ Аймгийн хэмжээнд барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл авсан 21 иргэн, хуулийн этгээдийн барилга байгууламжид Аймгийн мэргэжлийн хяналтын газар хамтран хяналт шалгалтыг хэрэгжүүлж ажилласан.



- ✚ Барилга, хот байгуулалтын яамны дэд сайдаар ахлуулсан, барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргатай хамтран Дархан Төмөрлөгийн үйлдвэр ТӨХК-тэй шинээр томилогдсон удирдлагатай танилцуулан мэдээллийг солилцож ажилласан.



Явуулсан бичиг:

- Улсын бүртгэлийн хэлтсээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 2013 онд ашиглалтад орсон "Минж проперти" ХХК-ний нийтийн орон сууцны дулаан зогсоолын тоог баталгаажуулан албан бичгээр хүргүүлсэн.
- Уур амьсгал, гамшигт тэсвэртэй орон сууцжуулах техникийн туслалцааны ажлыг эхлүүлэх, "Орлогод нийцсэн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлж,



санхүүгийн салбарыг сайжруулах” техникийн туслалцааны хүрээнд Монгол банкнаас ирсэн төлөөллүүдэд холбогдох мэдээллийг өгч ажилласан.

- Дархан-Уул аймгийн хэмжээнд 2020 онд ашиглалтад орсон болон 2022-2022 онуудад ашиглалтад орох нийтийн орон сууцны судалгааг ирүүлсэн маягтын дагуу хүргүүлсэн.
- Дархан-Уул аймаг, Дархан сум, 12-р багт байршилтай “Миракклэнд” ХХК-ний эзэмшлийн газарт спорт заалны зориулалттай барилгад барилгын ажил үргэлжлүүлэх зөвшөөрөл хүссэний дагуу хянаж үзэхэд барилга байгууламжийн экспертизийн дүгнэлт дутуу тул боломжгүй тухай албан бичгийг хүргүүлсэн.

Инженер, дэд бүтцийн хүрээнд:

Засгийн газрын 213-р тогтоолын дагуу барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг 1 барилгад олгосон. Үүнд:

- Дархан сумын 13-р багт баригдах ТК-80-ТК94 дулааны худгийн ажил эхлэх зөвшөөрөл хүсэлтийн дагуу холбогдох техникийн бичиг баримтыг судлаж зөвшөөрөл олгосон.
- Дархан-Уул аймгийн Хонгор суманд үерийн усны суваг угсралтын ажил, Монрок ХХК -ны цахилгааны шугам, Дархан сум 15-р багт хийгдэх үерийн усны сувгийн ажилд ажлуудын ажил эхлэх зөвшөөрөл хүссэн хүсэлтийн дагуу холбогдох техникийн бичиг баримтыг судлаж дутуу материал бүрдүүлсэн тул зөвшөөрөл олгох боломжгүйг албан тоотоор мэдэгдсэн.

Хүргүүлсэн албан тоот:

- Барилга хөгжлийн төвөөс ирүүлсэн албан бичгийн судалгааг хавсралт маягтын дагуу гаргаж хугацаанд нь хүргүүлсэн. Үүнд. 2020,2021 онд Дархан-Уул аймгийн хэмжээнд цэвэр усны шинжилгээний хариуг, сумдын инженерийн дэд бүтцийн судалгаа
- Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд инженерийн шугам сүлжээний мэдээллийн оруулж эхлүүлэхтэй холбоотойгоор аймгийн хэмжээнд авто зам, явган зам, цахилгааны шугам сүлжээний уртын мэдээллийг гаргаж хүргүүлсэн.



Газар чөлөөлөлт:

- Байгаль орчины уулзвараас Монгол банкны уулзвар хооронд авто зам өргөтгөлийн ажилтай холбогдуулан замын трассд орсон Баян бридж ХХК-ны орон сууцны гадна талд хийгдэх явган зам, Парк таун СӨХ-ны эзэмшилд байрлах автобусны зогсоолыг өргөтгөх ажлуудад тухайн хариуцагч байгууллагуудтай зөвшөлцөж саадгүй хийлгэсэн.
- Дархан суманд дугуйн зам хийгдэж байгаатай холбогдуулан Өргөө кино театрын баруун талд замын трасс дулааны шугамтай давхцал үүссэн тул Сод монгол групптэй зөвшөлцөж замын ажлыг саадгүй хийлгэсэн.

Бусад:



- Дархан хотоос малтай айл өрх, аж ахуй /гахай, тахиа/ эрхэлдэг айл, ААН-г гаргах ажлын хүрээнд байршлын зураг боловсруулж координат, байршлыг тогтоох.



3. ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦ, ДОТООД АЖЛЫН ЧИГЛЭЛ:

Шүүхийн мэдээлэл:

- Улаанбаатар менежмент ХХК-ний нэхэмжлэлтэй аймгийн Засаг даргад холбогдох Захиргааны хэрэгт холбогдуулж газар эзэмших эрхийг шилжүүлэхгүй байгаа нь хууль бус гэсэн нэхэмжлэлийн шаардлагад ГХБХБГ-ы ЗХАХМэргэжилтэн Б.Золбаясах хариу тайлбарыг боловсруулж Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд тайлбарыг хүргүүлсэн. Нэхэмжлэгч талаас компанид хувь оруулсан 2 иргэн нь 3-дагч этгээдээр оролцох хүсэлт гарсаныг шүүгчээр татгалзсан шийдвэр гарсаны дагуу Давах шатны шүүхрүү гомдол гаргасан, одоогоор шүүх хуралдааны тов зарлагдаагүй байна.
- “Алтантүрүү” ХХК-ны нэхэмжлэлтэй иргэний хэргийн шүүх хуралдааныг нэхэмжлэгч талаас хуулийн үйлчилгээ авах шаардлагатай тул 7 хоногоор хойшлуулах, өмгөөлөгч Б.Содболд хэргийн материалтай таницлах, хүсэлт гаргаж дахин хойшлуулж 2022/05/25-нд 09:00 цагт хуралдахаар шийдвэрлэсэн.

Хүний нөөц, дотоод ажлууд:

- 2022 оны 05-06 сард нийт 13 албан хаагчид батлагдсан хуваарийн дагуу “Газрын мэдээллийн цахим систем”-д иргэд, хуулийн этгээдээс газартай холбоотой өргөдөл, хүсэлт, лавлагаа, мэдээллийг egazag.gov.mn сайтаар илгээж, үйлчилгээг нээлттэй түргэн шуурхай хүргэж ажилласан.

Сургалт, зөвлөгөөн:

- Г.Жаргал /Док, Дэд пр/ “Төрийн албан хаагчийн ур чадварын түвшин, ёс зүйн үзэл, ёс суртахууны төлөвшил” сэдэвт цахим сургалт, Д.Сүнжид /Ph.D/ Хүний эрхийн үндэсний комиссын сургагч багшийн “Төрийн албан хаагчийн хөдөлмөрлөх эрх ба ялгаварлан гадуурхлаас ангид байх” сэдвээр ТАЗөвлөлөөс цахимаар зохион байгуулагдсан 7:4:10 сургалтуудад нийт 7 албан хаагч цахимаар оролцсон.



- ✚ Хуульчдын холбооноос багц цагийн сургалтад сургагч багш В.Энхтамир “Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт” сэдвээр Хүүхэд хөгжлийн төвд танхимаар зохион байгуулагдсан сургалтад ЗХАХМэргэжилтэн Б.Золбаясах, ГЗБТГӨАХАМэргэжилтэн Б.Баярмаа нар хамрагдаж газрын хууль эрх зүйн мэдлэгээ нэмэгдүүлсэн.

Хууль, тогтоомж:

- ✚ 8 иргэн, хуулийн этгээдийн Газар эзэмших эрхийг хүчингүй болгуулхаар аймгийн Засаг даргын захирамжийн төслийн боловсруулж, хяналтын хуудсаар тойрох хуудас зуруулж, аймгийн Засаг даргын туслах О.Уянгад файлаар хүргүүлсэн.
- ✚ Газрын эрх зүйн харилцааг хянан шийдвэрлэх 2022.05.20-ны өдрийн хурлаар 101 иргэн, хуулийн этгээдийн газрын асуудлыг танилцуулж, захирамжийн төсөлд илгээлээ.
- ✚ “Байгууллагын ёс зөвлөлийн дүрэм”, “Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг боловсруулж газрын тушаалаар 2022/05/23-ны өдрийн А/12 тоотор батлуулж, нийт албан хаагчдад танилцуулж, байгууллагын сайтад байршууллаа.
- ✚ ГЗБГЗЗГ-ын даргын 01 албан даалгаврын хэрэгжилтийг хагас жилийн байдлаар тайланг боловсруулж 2022/05/25-нд хүргүүлсэн.
- ✚ ГЗБГЗЗГ-т хагас жилийн байдлаар Хууль тогтоомжын хэрэгжилтийн тайланг боловсруулж, хүргүүлхээр ажиллаж байна.
- ✚ Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг газрын даргын 2022/05/23-ны өдрийн Б/13 тоот тушаалаар шинэчлэн батлуулсан.
- ✚ Сод монгол групп ХХК-ний Дархан захын хажууд байрлах ШТСтанцын үйл ажиллагаа явуулж, Худалдаа үйлчилгээний зориулалтын дагуу явуулахгүй байгааг 2022/04/29-ний өдрийн №246 тоот Мэдэгдэлийг хүргүүллээ.

ЭБАТ:

- ✚ Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын эрх зүйн харилцааны хуралдааны 5 дугаар сарын хуваарь болон барилгын ажлын хяналтын дагуу Ашиг сонирхлыг зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг 7 албан хаагчаас авч <https://meduuleg.iaac.mn/AOS/Login> бүртгэлд оруулсан. Газрын эрх зүйн харилцааны хуралдааны хуваарийн дагуу хуралдаж нийт **101** иргэн, хуулийн этгээдийн газартай холбоотой материалыг хэлэлцэж шийдвэрлэсэн.

Олон нийтийн ажил:

- ✚ Морин хууртай хөшөөний хойд уулын энгэрт Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэр бум мод” хөдөлгөөн, Дархан-Уул аймгаас “Ногоон дархан 2032” хөтөлбөрийн хүрээд “Шинэ иргэний төгөл” арга хэмжээг 2022/05/16-наас 17-ны өдрүүдэд аймгийн ЗДТГ-ын хэлтэс, агентлагын байгууллагын нийт албан хаагчид оролцож мод тарьсан. “Хараа гол” –ын эрэг дагуу байгууллагын заагдсан газарт нийт 160 ширхэг бургас суулгаж, хашаажуулсан.



Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар


16 May · 🌐

🌳 Монгол Улсын Ойн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийн хүрээнд хэрэ... See more



Байгууллагын Эцэг эхийн зөвлөл: “Хүүхэд хамгааллын жил 2022 он”

- ✚ Тус байгууллагын 2022 оны эцэг, эхийн зөвлөлийн ажлын төлөвлөгөөнд: Байгууллагын албан хаагчдын хүүхдүүдэд эрүүл мэндийн талаар сургалт зохион байгуулах тусгасаны дагуу нийт 41 хүүхдийг шүдний эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахаар “Харцтай” шүдний эмнэлэгт 2022-04-25 ны өдрийн 247 тоот албан бичгийг хүргүүлж хамтран ажллахаар болж, судалгааг хүснэгтэн байдлаар хүрүүлж, хамруулсан.
- ✚ Хүүхэд хамгааллын жил болгон зарласантай холбогдуулан эцэг, эхийн зөвлөл нь 2022 оны 05 дугаар сарын 14 -ны өдөр байгууллагын албан хаагчид “Гэр бүлийн явган аялал” -ыг зохион байгуулан ажиллаа.
- ✚ Эцэг, эхийн зөвлөл нь байгууллагын албан хаагчдын хүүхдүүдийг аймгийн Музей үйл ажиллагаа болон “Мандала” хөтөлбөрт хамрагдаж мандала утга учиртай танилцаж цагийг хөгжилтэй үр бүтээлтэй хамтран ажиллаа.





Мэдээлэл технологийн чиглэлээр:


- ✚ Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 70376471 нээлттэй утсаар 47, Facebook хуудсанд ирсэн 39 иргэн, ААНБ-ын асуултанд хариулт, зөвлөгөөг өгсөн.
- ✚ Байгууллагын архивт байгаа 9, 12-р багт байрлах гаражийн зориулалттай газруудын нэгж талбарын хувийн хэргийн баяжуулалтыг хийлээ. Нөхөн бүрдүүлэлтийн ажил хийгдэж буйтай холбогдуулан 9, 12-р багийн гаражуудын нэгж талбарын хувийн хэргийг архиваас татаж аван шинэчилсэн бүртгэлд хамрагдсан эсэхийг шалгаж хугацаа нь дууссан, шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй нэгж талбарын хувийн хэргүүдийг ангилсан.



- ✚ Байгууллагын цахим хуудсан дээр Санхүүгийн мэдээг 2016-2020, 2021-2025 оны хооронд харагдахаар салгаж, мэдээллийг зөөж байрлуулсан. Хүний нөөцийн мэдээлэлд засвар хийв. 2022 оны 3, 4-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, 3-р сарын 3,4-р долоо хоног, 4-р сарын 1, 2, 3, 4-р долоо хоногийн тайлан, 5-р сарын 1, 2, 3-р долоо хоногийн тайлан, 3, 4-р сарын тайланг оруулав.
- ✚ Байгууллагын цахим хуудсан дээр Дархан-Уул аймагт баригдаж буй барилгуудын үнийн мэдээ, “Төвийн бүсийн барилга ехро 2022 зохион байгуулагдах талаар мэдээлэлийг байрлуулсан.



- ✚ Фэйсбүүк хуудсан дээр Дархан-Уул аймагт баригдаж буй барилгуудын үнийн мэдээ, “Төвийн бүсийн барилга expo 2022 зохион байгуулагдах талаар мэдээлэл, “Шинэ иргэний төгөл”-д болон Хараа голын эрэг дээр мод тарьсан талаарх мэдээлэл, Байгууллагын албан хаагчдын хүүхдүүдийг шүдний эрүүл мэндийн үзлэгт оруулсан, гэр бүлийн явган аялал зохион байгуулсан талаарх мэдээлэл, Музейд очиж монгол үндэсний тоглоомоор тоглож сурсан талаарх мэдээлэл орууллаа.



Нярав:

- ✚ Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд 12 ширхэг нэгж талбарын хувийн хэргийн хавтас олгож, кадастрын мэдээллийн санд өөрчлөлт оруулсны төлбөрийн баримт 88 ширхэгийг хүлээж авч бүртгэсэн.
- ✚ Шаардах хуудсаар 6 төрлийн 19,5 ширхэг бараа материал олгов. 4-р сарын бараа материалын тайлангийн нэгтгэлийг гаргаж ня-бо-д өгөв

Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн талаар:

✚ ГХБХБГ-т 2022 оны 4 сарын 29-ний өдрөөс 5 сарын 23-ны өдрийн хооронд Абле программд нийт 94 албан бичиг /хариутай 74/, 25 өргөдөл /хариутай 24/ ирсэнээс 32 албан бичиг, 10 өргөдөл шийдвэрлэн, 42 албан бичиг, 14 өргөдөл хяналтанд бүртгэжээ.

Албан бичиг, өргөдлийн шийдвэрлэлтийг графикаар харуулбал:

График 1. Албан бичиг, өргөдлийн шийдвэрлэлт, хяналтанд авч судлаж буй талаарх мэдээлэл



Мөн Egazar.gov.mn системээр 177 өргөдөл хүсэлт хүлээн авсан бөгөөд тус системийн шийдвэрлэлтийн тайлан гаргадаг цэс нь одоогоор ажиллахгүй байгаа тул шийдвэрлэлтийн дүнг гаргах боломжгүй байна.

БОЛОВСРУУЛСАН:

ЗАХИРГАА, ХУУЛИЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.ЗОЛБАЯСАХ

ХЯНАСАН:

ГАЗРЫН УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Г.НЯМДОРЖ